МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.01.10 № 01/77

танай ______________-ны №______________-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Тэсгэвэр дарга нарт хуваарьт шинжлэн ажиллах 2024 I/12

2024 оны төсвийн хуваарь
хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай" А/02 дугаар тушаал, "Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай" А/03 дугаар тушаалыг тус тус хүргүүлж байна.

**Нэг. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн талаар:** Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын санд төсвийн жилд төвлөрүүлэх орлогыг 5,893.3 тэрбум, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаасыг 1,175.0 тэрбум, сангийн зарлагыг 5,188.4 тэрбум төгрөгөөр тус тус баталсан нь 2023 оны төсөвтэй харьцуулахад орлого 1,718.1 тэрбум төгрөгөөр, зарлага 1,035.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад дараах арга хэмжээнүүд тусгагдсан болно. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн орлогын хувьд:

- Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-д тусгагдсан арга хэмжээнүүд, тухайлбал шинээр малчин, туслах малчин, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцгийн төрөөс хариуцах шимтгэлийн орлого;

- Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчилэн тогтоосонтой холбоотойгоор нэмэгдэх шимтгэлийн орлого;

- Төрийн албан хаагчдын цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10.0 хувиар нэмэгдүүлэхтэй холбоотойгоор нэмэгдэх шимтгэлийн орлого;

-Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс сарын 660.0 мян.төг болсонтой холбоотойгоор нэмэгдэх шимтгэлийн орлого.

152407013

2. Нийгмийн даатгалын сангийн зарлагын хувьд:

- Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-д тусгагдсан арга хэмжээнүүд, тухайлбал шинээр ажил олгогч, даатгуулагчийг нэмж хамруулах, олон нийтэд чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зардал, Олон нийтийн хяналтын зөвлөлийн зардлын төсөв;

- Засгийн газрын 2023 оны "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238, "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дүгээр тогтоолоор бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2024 онд шаардагдах зардлын төсөв;

- Бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхэд шаардагдах зардлын төсөв;

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс сард 660.0 мян.төг болсонтой холбоотойгоор нэмэгдэх тэтгэмжийн зардлын төсөв зэрэг болно.

Иймд батлагдсан төсвийг дахин хуваарилах, нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах, шимтгэлийн авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад шуурхай хүргэх, тэтгэвэр, тэтгэмжийг батлагдсан төсвийн хүрээнд хуулиар тогтоосон хугацаанд олгох чиглэлээр дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

3. Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг зохион байгуулах;

4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 29.1-д заасны дагуу хүн амын болон ажил олгогчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч 2023 оны хүрсэн түвшингээс ажил олгогчийн тоог 5.0 хувь, даатгуулагчдын тоог 2.5 хувь, сайн дурын даатгуулагчдын тоог 10.0-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, малчдын сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх;

5. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлогын төлөвлөгөөг хариуцсан байцаагч бүрээр хуваарилан жигд хангаж биелүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2023 оны жилийн эцсийн үлдэгдлээс 60-аас доошгүй хувиар барагдуулахад онцгой анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

**Хоёр. Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн талаар:** Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын төсөв нь 2024 оноос Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу улсын төсвөөс санхүүжинэ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 55,375.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд уг зардлын төсөвт дараах арга хэмжээнүүд тусгагдсан болно. Үүнд:

1. Үндсэн цалингийн төсөвт:

- Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн үндсэн цалинг

шинэчлэн тогтоож 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаатай холбоотойгоор 2024 онд шаардагдах төсөв;

- Төрийн албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлэх зардлын төсөв;

2. Цалингийн нэмэгдлийн төсөвт:

- Нэмэгдсэн үндсэн цалингаас тооцож олгох төрийн албан хаасан хугацааны, зэрэг дэвийн нэмэгдлийн төсөв;

- Аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар, бусад суманд үндсэн цалингийн 40 хувиар тооцон 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэх төсөв;

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/137 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрэм”-д заасны дагуу мэргэшлийн зэрэг авсан байцаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгох нэмэгдлийн төсөв /Уг журам шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/73 дугаар “Дүрэм батлах тухай” тушаалаар мэргэшлийн зэргийн нэмэгдэл авч байсан байцаагчид нэмэгдлийг үргэлжлүүлэн олгоно/;

3. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөвт:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны “Унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/88 дугаар тушаалаар баталсан нормативыг баримтлан олгох нөхөх төлбөрийн зардлын төсөв;

4. Урамшууллын зардлын төсөвт:

- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн урамшууллыг үндсэн цалингийн 50 хүртэл хувиар тооцон улирал бүр олгох төсөв;

- Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цагийн хөлсийг Засгийн газрын 2023 оны “Дүрэм батлах, цагийн хөлсний хэмжээ тогтоох тухай” тогтоолоор баталсан, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүдийн урамшууллыг Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Цагийн хөлсний хэмжээ, олгох журам батлах тухай” А/154 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу тооцсон төсөв;

- Нийгмийн даатгалын төлөөлөгчид “Хөлсөөр ажиллах гэрээ”, ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн олгох ажлын хөлсний төсөв;

5. Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлын төсөвт:

Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын төсөв нь 2024 оноос нийгмийн даатгалын сангаас бус улсын төсвөөс санхүүжих бөгөөд санхүүгийн тайланг тус тусад нь гаргахтай холбоотойгоор аудит, баталгаажуулалтын нэмэгдэх зардлын төсөв;

6. Нийгмийн хамгааллын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийгмийн даатгалын салбарын хэмжээнд зөрчил, хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын төсөв /"бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн эдийн засгийн ангилалд тусгагдсан/;

7. Урсгал шилжүүлгийн төсөвт:

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т заасны дагуу сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа олгох зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллын зардлын төсөв; /"Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг" гэсэн эдийн засгийн ангилалд тусгагдсан тул уг урамшууллыг 1 дүгээр улиралд багтаан олгох./;

8. Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг мэдээлэл сурталчилгааны зардлын төсөв хасагдан нийгмийн даатгалын сангийн зарлагын төсөвт "ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээний зардлын төсөв" нэртэйгээр тусгагдсан болно.

Иймд Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн жилд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнчлэн Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлэх, үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилгыг мөрдөж ажиллахыг мэдэгдье.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 04 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.13.1, 37.14.2, Сангийн сайдын 2023 оны “Төсвийн хуваарь батлах тухай” 281 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус батал сугай.

Хоёр. Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгохыг Санхүү, бүртгэлийн газар /Б.Даваахүү/, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

Гурав. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг төсвийг захиран зарцуулах эрх бүхий энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын байгууллагуудын албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГА П.МӨНХЗУЛ

2024 1/12

1524010011

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 04 өдөр                Дугаар А/03                Улаанбаатар хот

Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.13.1, 37.14.2, Сангийн сайдын 2022 оны “Төсвийн хуваарь батлах тухай” 281 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/, Санхүү, бүртгэлийн газар /Б.Даваахүү/ нарт тус тус даалгасугай.

Гурав. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг төсвийг захиран зарцуулах эрх бүхий энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын байгууллагуудын албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГА                Л.МӨНХЗУЛ

Хяналтандаа авч ажиллая

Ц.Буянтогтох, О.Мэргэнцэцэг нарт
Батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулах
2024

1524010009

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн
А/03 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН САР, УЛИРЛЫН ХУВААРЬ

/мянган төгрөгөөр/

| Зардлын төрөл | Мөрийн дугаар | Нийт дүн | Үүнээс: | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 сар | 2 сар | 3 сар | 1-р улирал | 4 сар | 5 сар | 6 сар | 2-р улирал | 7 сар | 8 сар | 9 сар | 3-р улирал | 10 сар | 11 сар | 12 сар | 4-р улирал |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 УРСГАЛ ЗАРДАЛ | 1 | 1,490,525.8 | 117,534.9 | 106,936.8 | 159,217.1 | 383,688.8 | 114,567.6 | 96,938.2 | 132,285.9 | 343,791.7 | 123,115.6 | 87,371.4 | 95,991.7 | 306,478.7 | 114,854.0 | 95,130.8 | 246,581.8 | 456,566.6 |
| Бараа, үйлчилгээний зардал | 2 | 1,420,613.3 | 115,970.8 | 105,886.8 | 97,060.9 | 318,918.5 | 113,003.5 | 96,938.2 | 132,285.9 | 342,227.6 | 121,551.5 | 87,371.4 | 95,991.7 | 304,914.6 | 112,840.0 | 95,130.8 | 246,581.8 | 454,552.6 |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 3 | 1,337,438.2 | 98,495.7 | 102,252.2 | 96,364.7 | 297,112.6 | 95,528.4 | 96,242.0 | 131,589.7 | 323,360.1 | 104,076.4 | 86,675.2 | 95,295.5 | 286,047.1 | 95,364.9 | 94,434.6 | 241,118.9 | 430,918.4 |
| 2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал | 4 | 1,118,623.4 | 80,087.0 | 80,087.0 | 80,087.0 | 240,261.0 | 79,133.6 | 79,133.6 | 113,415.7 | 271,682.9 | 86,760.9 | 72,459.7 | 79,610.3 | 238,830.9 | 79,133.6 | 79,133.6 | 209,581.4 | 367,848.6 |
| 210101 Үндсэн цалин | 5 | 660,694.4 | 51,109.6 | 51,109.6 | 51,109.6 | 153,328.8 | 50,501.1 | 50,501.1 | 50,501.1 | 151,503.3 | 55,368.7 | 46,242.0 | 50,805.3 | 152,416.0 | 50,501.1 | 50,501.1 | 102,444.1 | 203,446.3 |
| 210102 Нэмэгдэл | 6 | 324,175.0 | 23,943.1 | 23,943.1 | 23,943.1 | 71,829.3 | 23,658.1 | 23,658.1 | 23,658.1 | 70,974.3 | 25,938.4 | 21,662.8 | 23,800.6 | 71,401.8 | 23,658.1 | 23,658.1 | 62,653.4 | 109,969.6 |
| 210103 Унаа хоолны хөнгөлөлт | 7 | 59,932.4 | 5,034.3 | 5,034.3 | 5,034.3 | 15,102.9 | 4,974.4 | 4,974.4 | 4,974.4 | 14,923.2 | 5,453.8 | 4,554.9 | 5,004.4 | 15,013.1 | 4,974.4 | 4,974.4 | 4,944.4 | 14,893.2 |
| 210104 Урамшуулал | 8 | 73,821.6 | - | - | - | - | - | - | 34,282.1 | 34,282.1 | - | - | - | - | - | - | 39,539.5 | 39,539.5 |
| 2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9 | 139,715.4 | 10,001.4 | 10,001.4 | 10,001.4 | 30,004.2 | 9,882.4 | 9,882.4 | 14,167.6 | 33,932.4 | 10,834.9 | 9,048.9 | 9,942.0 | 29,825.8 | 9,882.4 | 9,882.4 | 26,188.2 | 45,953.0 |
| 210201 Тэтгэврийн даатгал | 10 | 95,006.5 | 6,801.0 | 6,801.0 | 6,801.0 | 20,403.0 | 6,720.0 | 6,720.0 | 9,634.0 | 23,074.0 | 7,367.7 | 6,153.3 | 6,760.5 | 20,281.5 | 6,720.0 | 6,720.0 | 17,808.0 | 31,248.0 |
| 210202 Тэтгэмжийн даатгал | 11 | 11,177.2 | 800.1 | 800.1 | 800.1 | 2,400.3 | 790.6 | 790.6 | 1,133.4 | 2,714.6 | 866.8 | 723.9 | 795.4 | 2,386.1 | 790.6 | 790.6 | 2,095.0 | 3,676.2 |
| 210203 ҮОМШ өвчний даатгал | 12 | 8,941.8 | 640.1 | 640.1 | 640.1 | 1,920.3 | 632.5 | 632.5 | 906.7 | 2,171.7 | 693.4 | 579.1 | 636.3 | 1,908.8 | 632.5 | 632.5 | 1,676.0 | 2,941.0 |
| 210204 Ажилгүйдлийн даатгал | 13 | 2,235.4 | 160.0 | 160.0 | 160.0 | 480.0 | 158.1 | 158.1 | 226.7 | 542.9 | 173.4 | 144.8 | 159.1 | 477.3 | 158.1 | 158.1 | 419.0 | 735.2 |
| 210205 Эрүүл мэндийн даатгал | 14 | 22,354.5 | 1,600.2 | 1,600.2 | 1,600.2 | 4,800.6 | 1,581.2 | 1,581.2 | 2,266.8 | 5,429.2 | 1,733.6 | 1,447.8 | 1,590.7 | 4,772.1 | 1,581.2 | 1,581.2 | 4,190.2 | 7,352.6 |
| 2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15 | 36,241.0 | 3,571.5 | 3,473.0 | 3,209.2 | 10,253.7 | 3,209.2 | 3,209.2 | 1,890.2 | 8,308.6 | 1,982.4 | 1,890.2 | 3,209.2 | 7,081.8 | 3,473.0 | 3,473.0 | 3,650.9 | 10,596.9 |
| 210301 Гэрэл цахилгаан | 16 | 21,479.0 | 1,847.2 | 1,761.3 | 1,761.3 | 5,369.8 | 1,761.3 | 1,761.3 | 1,761.3 | 5,283.9 | 1,847.2 | 1,761.3 | 1,761.3 | 5,369.8 | 1,761.3 | 1,761.3 | 1,932.9 | 5,455.5 |
| 210302 Түлш, халаалт | 17 | 13,189.6 | 1,582.8 | 1,582.8 | 1,319.0 | 4,484.6 | 1,319.0 | 1,319.0 | - | 2,638.0 | - | - | 1,319.0 | 1,319.0 | 1,582.8 | 1,582.8 | 1,582.4 | 4,748.0 |
| 210303 Цэвэр, бохир ус | 18 | 1,572.4 | 141.5 | 128.9 | 128.9 | 399.3 | 128.9 | 128.9 | 128.9 | 386.7 | 135.2 | 128.9 | 128.9 | 393.0 | 128.9 | 128.9 | 135.6 | 393.4 |
| 210304 Байрны түрээс | 19 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2104 Хангамж, бараа материалын зардал | 20 | 17,653.5 | 2,831.1 | 1,236.1 | 1,236.1 | 5,303.3 | 1,298.5 | 1,516.1 | 1,266.2 | 4,080.8 | 2,493.5 | 1,266.2 | 1,258.0 | 5,017.7 | 1,207.9 | 1,145.6 | 898.2 | 3,251.7 |
| 210401 Бичиг хэрэг | 21 | 7,456.0 | 671.0 | 611.4 | 611.4 | 1,893.8 | 611.4 | 611.4 | 626.3 | 1,849.1 | 626.3 | 626.3 | 626.3 | 1,878.9 | 611.4 | 611.4 | 611.4 | 1,834.2 |
| 210402 Тээвэр, шатахуун | 22 | 3,500.0 | 315.0 | 287.0 | 287.0 | 889.0 | 287.0 | 287.0 | 294.0 | 868.0 | 294.0 | 294.0 | 294.0 | 882.0 | 287.0 | 287.0 | 287.0 | 861.0 |
| 210403 Шуудан,холбоо, интернэтийн төлбөр | 23 | 4,118.2 | 617.7 | 337.7 | 337.7 | 1,293.1 | 337.7 | 617.7 | 345.9 | 1,301.3 | 345.9 | 345.9 | 337.7 | 1,029.5 | 247.1 | 247.2 | (0.0) | 494.3 |
| 210405 Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал | 24 | 249.4 | 62.4 | - | - | 62.4 | 62.4 | - | - | 62.4 | 62.4 | - | - | 62.4 | 62.4 | - | (0.2) | 62.2 |
| 210406 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25 | 2,329.9 | 1,165.0 | - | - | 1,165.0 | - | - | - | - | 1,164.9 | - | - | 1,164.9 | - | - | - | - |
| 2106 Эд хогшил, урсгал засварын зардал | 26 | 3,378.7 | 665.4 | 179.2 | - | 844.6 | 665.4 | 179.2 | - | 844.6 | 665.4 | 179.2 | - | 844.6 | 844.7 | - | 0.2 | 844.9 |
| 210601 Багаж, техник, хэрэгсэл | 27 | 1,378.7 | 165.4 | 179.2 | - | 344.6 | 165.4 | 179.2 | - | 344.6 | 165.4 | 179.2 | - | 344.6 | 344.7 | - | 0.2 | 344.9 |
| 210604 Урсгал засвар | 28 | 2,000.0 | 500.0 | - | - | 500.0 | 500.0 | - | - | 500.0 | 500.0 | - | - | 500.0 | 500.0 | - | - | 500.0 |
| 2107 Томилолтын зардал | 29 | 4,905.0 | - | 2,452.5 | - | 2,452.5 | - | 1,471.5 | - | 1,471.5 | - | 981.0 | - | 981.0 | - | - | - | - |
| 210701 Гадаад албан томилолт | 30 | - | | | | - | | | | - | | | | - | | | - | - |
| 210702 Дотоод албан томилолт | 31 | 4,905.0 | - | 2,452.5 | - | 2,452.5 | - | 1,471.5 | - | 1,471.5 | - | 981.0 | - | 981.0 | - | - | - | - |
| 2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 32 | 5,047.2 | 23.3 | 3,973.0 | 981.0 | 4,977.3 | 23.3 | - | - | 23.3 | 23.3 | - | - | 23.3 | 23.3 | - | (0.0) | 23.3 |
| 210802 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 33 | 3,924.0 | - | 3,924.0 | - | 3,924.0 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210803 Даатгалын үйлчилгээ | 34 | 784.8 | - | - | 784.8 | 784.8 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210804 Тээврийн хэрэгслийн татвар | 35 | 196.2 | - | - | 196.2 | 196.2 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210806 Мэдээллийн технологийн үйлчилгээ | 36 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210807 Газрын төлбөр | 37 | 49.0 | - | 49.0 | - | 49.0 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210808 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 38 | 93.2 | 23.3 | - | - | 23.3 | 23.3 | - | - | 23.3 | 23.3 | - | - | 23.3 | 23.3 | - | 0.0 | 23.3 |
| 210809 Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 39 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2109 Бараа үйлчилгээний бусад зардал | 40 | 11,874.0 | 1,316.0 | 850.0 | 850.0 | 3,016.0 | 1,316.0 | 850.0 | 850.0 | 3,016.0 | 1,316.0 | 850.0 | 1,276.0 | 3,442.0 | 800.0 | 800.0 | 800.0 | 2,400.0 |
| 210901 Бараа үйлчилгээний бусад зардал | 41 | 10,010.1 | 850.0 | 850.0 | 850.0 | 2,550.0 | 850.0 | 850.0 | 850.0 | 2,550.0 | 850.0 | 850.0 | 810.1 | 2,510.1 | 800.0 | 800.0 | 800.0 | 2,400.0 |
| 210902 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 42 | 1,863.9 | 466.0 | - | - | 466.0 | 466.0 | - | - | 466.0 | 466.0 | - | 465.9 | 931.9 | - | - | 0.0 | 0.0 |
| 80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 43 | 8,910.0 | 696.2 | 696.2 | 696.2 | 2,088.6 | 696.2 | 696.2 | 696.2 | 2,088.6 | 696.2 | 696.2 | 696.2 | 2,088.6 | 696.2 | 696.2 | 1,251.8 | 2,644.2 |
| 2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал | 44 | 7,920.0 | 618.8 | 618.8 | 618.8 | 1,856.4 | 618.8 | 618.8 | 618.8 | 1,856.4 | 618.8 | 618.8 | 618.8 | 1,856.4 | 618.8 | 618.8 | 1,113.2 | 2,350.8 |
| 210104 Урамшуулал | 45 | 7,920.0 | 618.8 | 618.8 | 618.8 | 1,856.4 | 618.8 | 618.8 | 618.8 | 1,856.4 | 618.8 | 618.8 | 618.8 | 1,856.4 | 618.8 | 618.8 | 1,113.2 | 2,350.8 |
| 2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46 | 990.0 | 77.4 | 77.4 | 77.4 | 232.2 | 77.4 | 77.4 | 77.4 | 232.2 | 77.4 | 77.4 | 77.4 | 232.2 | 77.4 | 77.4 | 138.6 | 293.4 |
| 210201 Тэтгэврийн даатгал | 47 | 673.2 | 52.6 | 52.6 | 52.6 | 157.8 | 52.6 | 52.6 | 52.6 | 157.8 | 52.6 | 52.6 | 52.6 | 157.8 | 52.6 | 52.6 | 94.6 | 199.8 |
| 210202 Тэтгэмжийн даатгал | 48 | 79.2 | 6.2 | 6.2 | 6.2 | 18.6 | 6.2 | 6.2 | 6.2 | 18.6 | 6.2 | 6.2 | 6.2 | 18.6 | 6.2 | 6.2 | 11.0 | 23.4 |
| 210203 ҮОМШ өвчний даатгал | 49 | 63.4 | 5.0 | 5.0 | 5.0 | 15.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 15.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 15.0 | 5.0 | 5.0 | 8.4 | 18.4 |
| 210204 Ажилгүйдлийн даатгал | 50 | 15.8 | 1.2 | 1.2 | 1.2 | 3.6 | 1.2 | 1.2 | 1.2 | 3.6 | 1.2 | 1.2 | 1.2 | 3.6 | 1.2 | 1.2 | 2.6 | 5.0 |
| 210205 Эрүүл мэндийн даатгал | 51 | 158.4 | 12.4 | 12.4 | 12.4 | 37.2 | 12.4 | 12.4 | 12.4 | 37.2 | 12.4 | 12.4 | 12.4 | 37.2 | 12.4 | 12.4 | 22.0 | 46.8 |
| 80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал | 52 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 53 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210801 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний | 54 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 80213 Өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс | 55 | 392.4 | - | 392.4 | - | 392.4 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 56 | 392.4 | - | 392.4 | - | 392.4 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 210801 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний | 57 | 392.4 | - | 392.4 | - | 392.4 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 80219 Харуул, хамгаалалтын зардал | 58 | - | | | | - | | | | - | | | | - | | | - | - |
| 2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 59 | - | | | | - | | | | - | | | | - | | | - | - |
| 210801 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний | 60 | - | | | | - | | | | - | | | | - | | | - | - |

